

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тавантолгой төмөр зам ХХК -ийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/46/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2024 он

Санхүүгийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас:261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер: С.Нацагдорж  
Утас: 261885 Цахим хаяг: [natsagdorjs@audit.gov.mn](mailto:natsagdorjs@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Эрдэнэзул  
Утас: 261740 Цахим хаяг: [erdenezulb@audit.gov.mn](mailto:erdenezulb@audit.gov.mn)

Гэрээгээр гүйцэтгэсэн Гроут финанс Аудит ХХК-ийн  
Захирал: Б.Бямба  
Утас: 99094391 Цахим хаяг: [byambaa@growthfinance.mn](mailto:byambaa@growthfinance.mn)

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2024.03.25 № 07/809  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Н.БУДБАЯР  
ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 7,672.3 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон 303.8 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу эсвэл нийтээрээ материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Тухайлбал:

- Тус компани 4,349.8 сая төгрөгийн өртөг бүхий газар эзэмших эрхийг санхүүгийн тайланд бөөн дүнгээр бүртгэсэн;
- Ачаа тээврийн тарифын өөрчлөлтийг үнэн зөв бүртгээгүйгээс 2,326.1 сая төгрөгийн орлогыг дутуу илэрхийлсэн;
- Үлдэх өртөггүй 923.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй байна.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 304 дүгээр тогтоолоор тус компанийн 66.0 хувийг Эрдэнэс Тавантолгой ХК, 34.0 хувийг Монголын төмөр зам ТӨХК-д тус тус эзэмшүүлэхээр тогтоосон ба 2022 онд эзэмшигчийн өмчийн бусад хэсгээс

Z:\Yawsan\_Bichig\2024\0325 SNAG-8 Docx

0001051700

хувьцаанд хөрвүүлснээс хойш хувьцааны дүнд өөрчлөлт оруулаагүй, тайлант оны эцэст Эрдэнэс Тавантолгой ХК-ийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ 81.2 хувьд хүрсэн байна.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилга угсралтын ажлыг эхний байдлаар 2022 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр ашиглалтад оруулсан. Тус төслийн Эрчим хүч хангамж, Төмөр замын дээд, доод бүтэц, гүүр хоолой, хиймэл байгууламж, дохиолол холбоо, зэрлэгүүдийн зам, барилга байгууламжийг ашиглалтад оруулах Улсын комиссын 2023 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дүгнэлтээр төмөр замыг байнгын ашиглалтад хүлээн авсан байна.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 8 дугаар сарын 23-ний өдрийн 310 дугаар тогтоолоор Монгол Улс, Хятадын Улс хоорондын Гашуунсухайт-Ганцмод хил дамнансан төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг Тавантолгой төмөр зам ХХК-д 5 жилийн хугацаатай олгосон ба тайлант онд уг төслийн ажлыг эхлүүлээд байна.

### **Аудитын гол асуудал**

Тус компанид хэрэгжиж буй төслүүдийн гүйцэтгэл тайлант жилийн эцсийн байдлаар Тавантолгой-гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн явц 87.6 хувь, Шилжүүлэн ачих терминал 98.0 хувь, Тавантолгой-гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын төсөл 95.4 хувь, Тавантолгой нүүрс ачих ложистикийн төв 82.0 хувь, Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнансан төмөр замын төсөл 5.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам, Богдхан төмөр зам, Тавантолгой-Гашуунсухайт, Зүүнбаян төмөр замын холболт зэрэг төслүүдийн худалдан авалт, зураг төсөл, гэрээ, ажлын гүйцэтгэл зэрэгтэй холбоотой нөхцөл байдал нь Тавантолгой төмөр зам ХХК-ийн хяналтаас гадуур, урьдчилан таамаглах, даван туулах, сэргийлэх, арга хэмжээ авах боломжгүй нөхцөл байдалтай байгаа талаар давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээг Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхимаас гаргасан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Мөр-ийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	43,554,885,095.17	69,980,171,532.25
1.1.2	Дансны авлага	5,442,865,128.97	7,640,780,763.58
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	171,084,703,773.90	179,879,526,123.04
1.1.4	Бусад авлага	746,338,319.57	3,367,892,980.85
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	4,001,298,846.69	17,648,365,774.68
1.1.6	Бараа материал	514,895,094.41	1,116,456,943.89
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	357,582,745,815.89	1,478,399,073,976.38
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>582,927,732,074.60</b>	<b>1,758,032,268,094.67</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	148,842,894,732.11	142,376,136,535.74
1.2.2	Биет бус хөрөнгө	230,583,769,392.28	230,602,316,045.89
1.2.3	Бусад эргэлтийн бус хөрөнгө	2,066,239,238,144.61	2,223,391,729,729.91
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>2,445,665,902,269.00</b>	<b>2,596,370,182,311.54</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,028,593,634,343.60</b>	<b>4,354,402,450,406.21</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	328,079,048,468.14	408,281,720,868.64
2.1.1.2	Цалингийн өглөг	1,693,980.23	1,336,890,811.46
2.1.1.3	Татварын өр	1,253,664.05	444,799,954.36
2.1.1.4	НДШ-ийн өглөг		
2.1.1.5	Урьдчилж орсон орлого	261,711,500.00	18,981,640,178.75
2.1.1.6	Бусад богино хугацаат өр төлбөр	133,230,024.38	20,231,777,275.59
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>328,476,937,636.80</b>	<b>449,276,829,088.80</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Хойшлогдсон татварын өр	182,519,636.11	1,032,415,607.20
2.1.2.2	Бусад урт хугацаат өр төлбөр		
	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>182,519,636.11</b>	<b>1,032,415,607.20</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>328,659,457,272.91</b>	<b>450,309,244,696.00</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	2,040,479,750,000.00	2,040,479,750,000.00
2.3.2	Эздийн өмчийн бусад хэсэг	659,125,216,436.83	1,858,936,268,852.87
2.3.3	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	329,210,633.87	4,677,186,857.34
	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>2,699,934,177,070.70</b>	<b>3,904,093,205,710.21</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,028,593,634,343.61</b>	<b>4,354,402,450,406.21</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөр-ийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого	8,071,333,403.83	31,207,609,931.24
2	Борлуулалтын өртөг	10,239,505,582.48	36,351,842,956.23
3	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>(2,168,172,178.65)</b>	<b>(5,144,233,024.99)</b>
4	Түрээсийн орлого	2,562,660,922.85	7,014,728,181.81
5	Хүүний орлого	1,184,776,948.24	3,472,953,765.68
6	Бусад орлого	18,498,819.12	1,161,874,750.14
7	Ерөнхий ба удирдлагын зардал	2,911,110,081.32	862,713,874.95
8	Бусад зардал	2,541,716.18	22,419,990.40
9	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(1,315,887,285.94)</b>	<b>5,620,189,807.29</b>
10	Орлогын татварын зардал	247,300,815.43	1,197,191,347.66
11	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(1,563,188,101.37)</b>	<b>4,422,998,459.63</b>
12	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>	-	-
13	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>(1,563,188,101.37)</b>	<b>4,422,998,459.63</b>
14	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	-	-
15	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(1,563,188,101.37)</b>	<b>4,422,998,459.63</b>
16	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>	(1.92)	5.42

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөр-ийн №	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>3,342,550,591.98</b>	<b>5,784,060,867.28</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,258,639,828.32	3,163,907,361.50
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	17,842,273.95	54,105,818.78
1.1.6	Бусад мөнгөн орлого	66,068,489.71	2,566,047,687.00
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>57,358,112,514.14</b>	<b>87,429,319,573.98</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	12,655,486,277.75	7,452,525,185.06
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	4,219,728,909.66	901,034,235.83
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,580,900,371.42	650,665,496.06
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	282,966,370.41	133,806,357.80
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,897,799,722.77	1,009,867,712.58
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,630,774,119.08	330,644,831.58
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	25,219,545.00	33,059,795.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	32,065,237,198.05	76,917,715,960.07
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(54,015,561,922.16)</b>	<b>(81,645,258,706.70)</b>
2	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>1,184,776,948.24</b>	<b>409,087,989.63</b>
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	1,184,776,948.24	409,087,989.63
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>339,865,673,056.84</b>	<b>3,273,283,883.77</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	89,443,625,740.83	3,234,570,605.77
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	15,430,000.00	38,713,278.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	4,001,298,846.69	
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	246,405,318,469.32	
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(338,680,896,108.60)</b>	<b>(2,864,195,894.14)</b>
3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>423,873,971,998.26</b>	<b>87,227,295,335.64</b>
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	423,873,971,998.26	87,227,295,335.64
3.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	-	
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>423,873,971,998.26</b>	<b>87,227,295,335.64</b>
5	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>31,177,513,967.50</b>	<b>35,178,812,814.19</b>
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>12,377,371,127.67</b>	<b>43,554,885,095.17</b>
7	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>43,554,885,095.17</b>	<b>69,980,171,532.25</b>

**2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

№	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>467,503,000,000.00</b>	<b>1,601,311,127,008.50</b>	<b>1,104,428,900.52</b>	<b>2,069,918,555,909.02</b>
2	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	787,969,834.70	<b>787,969,834.70</b>
3	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>467,503,000,000.00</b>	<b>1,601,311,127,008.50</b>	<b>1,892,398,735.22</b>	<b>2,070,706,525,743.72</b>
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(1,563,188,101.35)	<b>(1,563,188,101.35)</b>
5	Өмчид гарсан өөрчлөлт	1,572,976,750,000.00 -	(942,185,910,571.61)	-	<b>630,790,839,428.39 -</b>
6	<b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>2,040,479,750,000.00</b>	<b>659,125,216,436.89</b>	<b>329,210,633.87</b>	<b>2,699,934,177,070.76</b>
7	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(75,022,236.16)	<b>(75,022,236.16)</b>
8	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>2,040,479,750,000.00</b>	<b>659,125,216,436.89</b>	<b>254,188,397.71</b>	<b>2,699,859,154,834.60</b>
9	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			4,422,998,459.63	<b>4,422,998,459.63</b>
10	Өмчид гарсан өөрчлөлт		1,199,811,052,416.04		<b>1,199,811,052,416.04</b>
11	<b>2023 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл</b>	<b>2,040,479,750,000.00</b>	<b>1,858,936,268,852.93</b>	<b>4,677,186,857.34</b>	<b>3,904,093,205,710.27</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/ мянган төгрөг /

Д/д	Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 оны төлөвлөгөө	2023 оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Тээврийн үйл ажиллагаа (мян.тоо)	246.1	1,970.8	1,965.1	5.76	99.7%
2	<b>Нийт орлого</b>	<b>11,837,270.1</b>	<b>42,963,431.3</b>	<b>42,857,166.6</b>	<b>106,264.70</b>	<b>99.8%</b>
2.1	Цэвэр борлуулалт	8,071,333.4	32,990,626.6	31,207,609.9	1,783,016.70	94.6%
2.2	Бусад орлого	3,765,936.7	9,892,804.7	11,649,556.7	(1,756,752.00)	117.8%
2.2.1	Хүүгийн орлого	1,184,776.9	1,829,345.4	3,472,953.8	(1,643,608.40)	189.8%
2.2.2	Түрээсийн орлого	2,562,660.9	7,444,038.7	7,014,728.2	429,310.50	94.2%
2.2.3	Бусад орлого	18,498.8	619,420.6	1,161,874.8	(542,454.20)	187.6%
3	Төслийн санхүүжилт	21,842,293.8	17,877,384.3	18,758,501.3	(881,117.00)	104.9%
3.1	Таван-толгой Гашуунсухайт төмөр зам төсөл	17,000,000.0	17,797,384.3	18,758,501.3	(961,117.00)	105.4%
3.2	Холболтын төмөр зам төсөл	4,842,293.8	80,000.0	-	80,000.00	0.0%
4	<b>Нийт зардал</b>	<b>13,153,157.4</b>	<b>41,260,967.5</b>	<b>37,236,976.8</b>	<b>4,023,990.70</b>	<b>90.2%</b>
4.1	Борлуулалтын өртөг	10,239,505.6	40,108,057.3	36,351,843.0	(3,756,214.30)	90.6%
4.1.1	Тээврийн үйл ажиллагаа	9,649,413.9	39,055,833.9	35,847,612.7	(3,208,221.20)	91.8%
4.1.2	Төслийн үйл ажиллагаа ТНАЛТ	590,091.7	1,052,223.4	504,230.3	(547,993.10)	47.9%
4.2	Ерөнхий удирдлагын зардал	2,911,110.1	1,152,910.2	862,713.9	(290,196.30)	74.8%
4.3	Бусад зардал	2,541.7	-	22,419.9	22,419.90	0.0%
5	Захиалагчийн хяналтын зардал	18,442,664.7	17,270,621.6	13,038,718.5	(4,231,903.10)	75.5%
5.1	Таван-толгой Гашуунсухайт төмөр зам төсөл	15,950,640.9	15,767,272.3	12,128,894.8	(3,638,377.50)	76.9%
5.2	Холболтын төмөр зам төсөл	1,423,752.2	1,087,918.8	656,971.4	(430,947.40)	60.4%
5.3	Хил холболтын зардал		415,430.5	198,861.0	(216,569.50)	47.9%
5.3	Богдхан төмөр зам төсөл	1,068,271.6	-	53,991.3	53,991.30	0.0%

**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 63,379.9 сая төгрөгийн, 5 алдаа илэрснээс аудитын явцад нийт 52,822.1 сая төгрөгийн 3 алдааг залруулж, нийт 10,557.8 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант жилийн эцэст хугацаа хэтэрсэн авлагуудаас одоогийн мөрдөгдөж байгаа бодлогын дагуу 2 байгууллагад найдваргүй авлагын хасагдуулга тооцсон ба уг найдваргүй авлагын зардлыг ерөнхий удирдлагын зардлаар бүртгэсэн	1	19,708.0		-	1	19,708.0	1	19,708.0				
Банкинд тусдаа данстай хадгаламжийн дансдын хооронд хийсэн ажил гүйлгээг компани нэг журналаар бүртгэж тэдгээрийн хооронд хийсэн гүйлгээ журналд бүртгээгүй. орхисон	1	41,438,310.1	1	41,438,310.1		-	1	41,438,310.1				
Нийт 11 тэрбум төгрөгийн гурван сараас дээш хугацаатай 2	1	11,364,089.1		-	1	11,364,089.1	1	11,364,089.1				

Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

хадгаламжийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөөр тайлагнаж санхүүгийн хөрөнгийг зөв ангилаагүй.												
НӨАТ-ын тайлангийн үлдэлдлийг санхүүгийн тайлангийн үлдэгдэлтэй тулгаж шалгахад НӨАТ-ын тайлангаарх үлдэгдэл нь санхүүгийн тайлангийн НӨАТ-ын авлагаас 1,271.5 сая төгрөгөөр дутуу тайлагнасан зөрүүтэй байна.	1	1,271,477.1			1	1,271,477.1			1	1,271,477.1	1	1,271,477.1
Тайлант оны НӨАТ-ын тайланд 9,286.3 сая төгрөгийн хувь тэнцүүлэн НӨАТ-ын хасалтыг илүү тайлагнасан байна.	1	9,286,274.0			1	9,286,274.0			1	9,286,274.0	1	9,286,274.0
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>63,379,858.2</b>	<b>1</b>	<b>41,438,310.1</b>	<b>4</b>	<b>21,941,548.1</b>	<b>3</b>	<b>52,822,107.1</b>	<b>2</b>	<b>10,557,751.1</b>	<b>2</b>	<b>10,557,751.1</b>

Аудитаар нийт 7,672.3 сая төгрөгийн 16 зөрчил илэрснээс 14,722.6 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 3,307.8 сая төгрөгийн 6 албан шаардлага, 4,349.7 сая төгрөгийн 8 зөвлөмж өгч ажиллааа.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Гүйцэтгэх захирал, Төсөл судалгааны хэлтсийн дарга, Засгийн газрын бүрэн эрхэт төлөөлөгчийн ажлын албаны дарга, Бүрэн эрхэт төлөөлөгч гэх мэт 6 удирдах ажилтан нарын унасан Land Cruiser 200, Sonata 8 гэх мэт 7 автомашины чиглэл зорилго тодорхойгүй, хот дотор унасан тээврийн хэрэгслэлийн шатахуунд 6,536,857.60 төгрөг олгосон байна.	1	6,536.9	1	6,536.9								
Хуулиар зөвшөөрөөгүй дараах зардлуудыг гаргасан байна. (1)ТУЗ-н ажлын албаны ажилтны хувийн машинд 1-11 дүгээр сард 300.0 мянган төгрөг буюу нийт 3.3 сая төгрөгийн шатахуун олгосон. (2). Бүрэн эрхэт төлөөлөгч болон Бүрэн эрхэт төлөөлөгчийн ажлын албаны дарга нар байгууллагын машин унахдаа өөрсдийн гэрийн ойролцоо граж түрээслэсэн төлбөр 4.8 сая төгрөг зарцуулсан.	1	8,185.8	1	8,185.8								

Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

<p>Үндэсний аудитын газрын 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 705 /АО150458 тоот зөрчил арилгах тухай албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй нийт 923,238,068.14 /есөн зуун хорин гурван сая хоёр зуун гучин найман мянга жаран найман/ төгрөгийн 492 ширхэг үндсэн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй.</p>	1	923,238.1			1	923,238.1			1	1
<p>Өмнөх оны аудитаар өгсөн хоосон чингэлгийн тарифыг 90 хувиар хөнгөлсөн асуудалд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэхийн тулд Бүрэн эрхэт төлөөлөгчийн 2023 оны А/37 дугаар тушаалаар хоосон чингэлгийн тарифыг 90 хувиар хөнгөлөлт үзүүлсэнийг хүчингүй болгосон ч уг тушаалыг холбогдох ажилтнууд болон ЭТТ ХК-д танилцуулаагүйгээс тариф хөнгөлттэй хэвээр тооцогдож, тээврийн үйлчилгээний орлогыг 3,775,030,272.00 (гурван тэрбум долоон зуун далан таван сая гучин мянга хоёр зуун далан хоёр) төгрөгөөр дутуу илэрхийлсэн.</p>	1	2,326,126.7			1	2,326,126.7				
<p>Үндэсний аудитын газрын 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 182/АО150458 тоот төлбөр барагдуулах актаас 8,418,366.00 /найман сая дөрвөн зуун арван найман мянга гурван зуун жаран зургаан/ төгрөг, 180/АО150458 тоот төлбөр барагдуулах актаар тогтоосон 23,400,000.00 /хорин гурван сая дөрвөн зуун мянга/ төгрөг</p>	1	31,818.4			1	31,818.4				

Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

нийт 31,818,366.00 /гучин нэгэн сая найман зуун арван найман мянга гурван зуун жаран зургаан/ төгрөгийн төлбөр төлөгдөөгүй байна.												
Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг ажилтны санаачилгаар цуцлахаар зохицуулсан ба ажилтны санаачилгаар хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан тохиолдолд тэтгэмж олгохгүй. Гэвч тайланд онд 2 ажилтны санаачилгаар хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгосон боловч компанийн зүгээс 20,000,000.00 /хорин сая/ төгрөгийн тэтгэмж олгосон байна.	1	20,017.8			1	20,017.8						
Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлангийн 5.3.13-д заасан НББББ-тээ байгууллагын үйл ажиллагааны онцлог болон хууль стандартын өөрчлөлтийг тогтмол тусган шинэчилж байх талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1	-			1	-						
Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлангийн 5.3.14-д заасан өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй буюу авлага, өглөгийн товчоо тайлангийн эхний үлдэгдлийн зөрүүг программд тохируулж зохих засвар сайжруулалт хийгээгүйгээс программ дахь тайлант жилийн үлдэгдэл зөрүүтэй хэвээр байна.	1	-			1	-						
Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 03 дугаар тогтоолоор хуучин ТУЗ-ийн 7 шигүүний бүрэн эрхийн хугацааг	1	-					1		-			

дуусгавар болгож, шинээр 7 гишүүнийг томилсон ба тэдгээрийг сонгож томилохдоо хуулийн дагуу сонгон шалгаруулаагүй, олон нийтэд мэдээлээгүй												
Гашуун сухайт чиглэлийн төмөр замтай холбоотой хөрөнгийг Бодь интернейшнл ХХК-аас зөвхөн биет байдлаар хүлээлцсэн байна. Гүйцэтгэгч компаниас хөрөнгийн үнийг гэрээнд заасны дагуу хувийн жингээр тооцож байгааг захиалагчийн зүгээс үнэ өртгийг хүлээн авах боломжгүй гэж үзсэний улмаас данс бүртгэлд тусгаагүй байна.	1	-					1	-				
Гүйцэтгэгчээс Гашуунсухайт төслийн болон /IPC 24-30/, Холболтын төслийн явц дундын гүйцэтгэл /IPC 9-14/ баталгаажуулах хүсэлт ирүүлсэнийг захиалагчийн хяналтын хэлтсээс ажлын тоо хэмжээг шалгаж баталгаажуулсан боловч Гүйцэтгэх захирал үнийн дүн бүхий гүйцэтгэлүүдийг /IPC/ эцэслэж батлаагүйгээс тэдгээр төслийн гүйцэтгэлийг санхүүгийн тайланд бүрэн тусгаагүй байна.	1	-					1	-				
Гашуунсухайт төслийн хүрээнд ТЭЗҮ-д тусгагдаагүй 146.4 сая ам.долларын нэмэлт ажлуудыг гүйцэтгэгч компанийн ирүүлсэн үнийн саналын дүнгээр нэмэлтээр гүйцэтгүүлэхээр албан бичгээр тохирсон. Ингэхдээ гүйцэтгэгч компаниас ирүүлсэн үнийн санал дахь дүн нь зах зээлийн бодит үнэ цэнээр байгаа эсэхийг нягталсан эсэх нь тодорхойгүй байна.	1	-					1	-				

Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Монголын төмөр зам ТӨҮГ-аас 2019 онд хөрөнгө оруулалтаар ирсэн 230,602.3 сая төгрөгийн өртөг бүхий газар эзэмших эрхийг санхүүгийн тайланд бөөн дүнгээр бүртгэсэн. Тавантолгой төмөр зам ХХК-ийн нэр дээр 5 газар эзэмших эрх бүртгэлтэй байгаа ба тэдгээрийн 1 эрхийг 53 жил, бусад эрхүүдийг 15 жилийн хугацаатай эзэмшүүлсэн байна. Газар эзэмших эрхүүдийг данс бүртгэлд тус бүрээр нь салгаж бүртгээгүй тул тэдгээрийн хорогдлыг тооцох боломжгүйгээс тэдгээрийн хорогдлыг тооцож бүртгээгүй байна.	1	4,349,781.1					1	4,349,781.1				
Нэг ижил мэргэжлийн албан тушаалын цалинг өөрөөр тогтоосноор зарим ажилтнуудаас цалинг нэмэгдүүлэх талаар гомдол гаргасан байна.	1	-					1	-				
Хотод албан ажлын хэрэгцээнд ашигладаг автомашинуудын анхан шатны баримтаас түүвэрлэлт хийн шалгахад 14,127 км аялал замын хуудас хөтлөөгүй	1	-					1	-				
Ачааны мэдээнээс түүвэрлэн анхан шатны баримттай тулган шалгахад нэг удаагийн гарсан ачааны мэдүүлэг дээр дахин баримт үүсгэсэн, хяналт шалгалт хийж тооцооллыг давтан хийх явцад илэрсэн дутуу дүнг нөхөн баримт хавсаргасан зэрэг механик алдаа гарах эрсдэлтэй нөхцөл байдал бий болохоор байна.	1	-					1	-				
<b>Дүн</b>	<b>16</b>	<b>7,665,704.7</b>	<b>2</b>	<b>14,722.6</b>	<b>6</b>	<b>3,301,200.9</b>	<b>8</b>	<b>4,349,781.1</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар илэрсэн нийт 38.4 сая төгрөгийн 3 зөрчлөөс 38.4 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, Компанийн тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг талаар нийт 2 зөвлөмж өглөө.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Худалдан авалтын төлөвлөгөө оройтож батлагдсан болон эхний сонгон шалгаруулалтаар шаардлага хангасан тендэр ирээгүй зэргээс шалтгаалж, өмнөх гэрээг үргэлжлүүлэх болсонтой холбогдуулан “Грийн мотор” ХХК-тай дахин гэрээ байгуулахдаа гэрээний үнийг нэмэгдүүлж, 38,4 (гучин найман сая дөрвөн зуун гучин мянга) төгрөгийн илүү зардал гаргасан байна.	1	38,430.0	1	38,430.0	-	
Компанийн тодотгосон төлөвлөгөөг шаардлагатай хугацаанд нь хэлэлцэж батлаагүйгээс жилийн эцэст буюу 2023 оны 11 дүгээр сард баталж байгаа нь төлөвлөөгүй ажлыг хэрэгжүүлсэн болон биелүүлээгүй гүйцэтгэлд тохируулан тодотголыг хийсэн байна	1	-			1	-
Хөдөлмөрийн дотоод журамдаа ажилтнуудад олгох тэтгэмжийн хэмжээг Хөдөлмөрийн тухай хуульд зааснаас зөрүүтэй олгохоор заасан нь хууль нийцээгүй тэтгэмж олгох эрсдэлтэй байна	1	-			1	-
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>38,430.0</b>	<b>1</b>	<b>38,430.0</b>	<b>2</b>	<b>-</b>